

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл
ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2019 оны 4-р сарын 18-ны өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Үүнд: “Алдарт эх” 1, 2 дугаар одонд тодорхойлох тухай, Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсэг байгуулах тухай, Ой тэмдэглэх тухай /Хотонт сумын Өндөр-сант багийн дунд сургуулийн 80 жилийн ой/, Өмчийн тухай

“Жэрэс” олон улсын байгууллагатай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 18 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга нар, цаг уурын ажилтнууд, сумдын удирдлагуудад уур амьсгалын өөрчлөлт, түүнийг даван туулах, дасан зохицох асуудлыг орон нутгийн бодлогын баримт бичигт тусгах, бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй сэдэвт сургалтыг зохион байгуулж 400 гаруй хүнийг хамруулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 70.494.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 51 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 2019 онд 38.260.7 сая төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 3.420.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 35 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 4-р сарын 25-ны өдрийн 10.00 цагт аймгийн ЗДТГ-ын VIP танхимд зохион байгууллаа. Зөвлөгөөнд 51 удирдах ажилтан оролцохоос аймгийн ЗДТГ-ын нэгжийн дарга 7, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга 21, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга 14, нийт 42 удирдах ажилтан оролцож, ирц 82.3 хувь байлаа.

Зөвлөгөөний үеэр аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 2019 оны 3-р сарын 25-ны өдрийн шуурхай зөвлөгөөний үеэр аймгийн Засаг даргаас өгсөн 14 үүрэг даалгаврын биелэлтийн явцыг танилцуулж, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэбулган сумаас аймгийн хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээлэл, сумын цаг үеийн ажил, хот тохижилт, хог цэвэрлэгээ, үйлчилгээний талаар мэдээлэл хийв.

Энэ удаагийн зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргаас цаашид эрчимжүүлж, сайжруулах ажил арга хэмжээний талаар 15 төрлийн үүрэг даалгаврыг байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт өгч, үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох хэлтэс, албан тушаалтанд үүрэг болголоо.

Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн нээлтийн арга хэмжээ болон хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийг 4-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

"Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн гол онцлог нь Засгийн газраас мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан иргэн төвтэй ухаалаг үйлчилгээг хөгжүүлж, төрийн цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг бүрэн холбож, төрийн 320 орчим үйлчилгээг цахимаар үзүүлж, шуурхай, цаасгүй, нээлттэй, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг бий болгох юм.

Мөн төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа үйлчилгээний стандартыг шинэчлэн тогтоож мөрдүүлэх, төрийн үйлчилгээний менежментийг олон улсын түвшинд хүргэх, төрийн үйлчилгээний шимтгэл, хураамжийг бууруулж, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн санал, дүгнэлтээр төрийн үйлчилгээний үнэлэмжийг тогтоон, төрийн үйлчилгээг удирдах, хянах, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэн иргэдтэй зөвлөлдөх санал асуулгын үйл ажиллагааг төрийн үйлчилгээний байгууллагуудад нэвтрүүлэхээр зорьж байна. Жилийн нээлтийн үйл ажиллагаанд 20 гаруй байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын чиглэлийн өмчийн бүх төрлийн 88 байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, ажилтнууд, ажил олгогч нарын зэрэг 470 гаруй хүн оролцсон байна. Дээрхи арга хэмжээнд 600 гаруй иргэн оролцож, мэдээлэл үйлчилгээ авсан.

Аймгийн ЗДТГ-аас залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, төрийн үйлчилгээ гэх мэт тэдний өмнө тулгамдаж буй асуудлууд, хэрхэн шийдвэрлэж болох талаар "Залуучуудаа сонсьё" чөлөөт уулзалт ярилцлагыг 4-р сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Энэ үеэр аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасан 2016-2019 онуудад орон нутагт хийж, хэрэгжүүлсэн болон цаашид төлөвлөсөн ажлуудын талаар дэлгэрэнгүй танилцуулж, мэдээлэл өгсөн бөгөөд уулзалтад 200 гаруй залуучууд оролцлоо.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдын сургалтыг 4 дүгээр сарын 19-ний өдөр аймгийн ЗДТГ-ын Ногоон танхимд зохион байгууллаа. Сургалтаар Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Төрийн албаны тухай хуулийн хүрээнд шинээр гарсан дүрэм журам, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2019 оны А/99-р захирамжаар баталсан "Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам", А/100-р захирамжаар баталсан "Агентлаг, сумын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх журам"-уудыг танилцуулж, 2018 оны үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хийж арга зүйн зөвлөгөө өглөө. Сургалтад нийт 27 албан хаагч оролцсон байна.

"Орон нутаг дахь батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ" сургалтыг сумын ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нарыг оролцуулан аймгийн Цэргийн штабаас 4-р сарын 11-ний өдөр зохион байгууллаа.

4-р сарын 19-ний өдөр МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулиас "Боловсролын шинэчлэл, багшийн хөгжил" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Энэ хуралд Монгол, БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ,

Камерун Улсын зэрэг долоон орны эрдэмтэн судлаачид дээрх сэдвийн хүрээнд өөрсдийн судалгаа шинжилгээний илтгэлийг хэлэлцүүлж аймгийн Засаг даргын орлогч Б.Болормаа, МУБИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор (Ph.D) дэд профессор Х.Тамир, МУБИС-ийн Захиргаа, хүний нөөцийн асуудал эрхэлсэн дэд захирал Б.Сүхболд нарын төлөөллүүд оролцсон юм.

Монгол Улсад атар газар эзэмшсэний 60 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Архангай аймагт атар газар эзэмшсэний 60 жилийн ойн нээлт, сургалт, зөвлөгөөн 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлтийн талаар

4-р сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувьтай байна.

Тайлант хугацаанд 3-р сарын нэмэгдсэн өртгийн албан татварын 209 тайлан, 1-р улирлын ААНОАТ-ын 980, ЦХХ-ны 1667 тайлан, төлбөр хураамжийн 45 тайлан цахимаар хүлээн авч тайлангийн ирцийг 99.5 хувьтай хангуулж, шалгуур үзүүлэлт хангаагүй байцаагчид хуваарилагдсан 152 тайланг тайлан хүлээн авах журмын дагуу хүлээн авч баталгаажууллаа.

Тайлант хугацаанд 17 иргэн, аж ахуйн нэгжид тендерт оролцох виз хүссэн, зээл авах, бусад төрлүүдээр лавлагаа тодорхойлолт гаргаж, цахимаар ирүүлсэн тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, тоон гарын үсэг авах зэрэг 440 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Цахим тайлангийн системд нэвтрэх хүчинтэй хугацаа дууссан 1113 ААНБ-н цахимд нэвтрэх нууцийг дахин олгосон байна.

Санхүүгийн хяналтын чиглэлээр

Санхүүгийн хяналт аудитын албаны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг дарга болон албаны даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ-ын 2018 оны, ус суваг ашиглалтын “Ар ус ундарга” ХХК-ийн 2019 оны эхний 3 сарын үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалтыг иргэд, байгууллагын хүсэлтээр холбогдох асуудлыг улсын байцаагчийн хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудит, хяналт шалгалтаар улсын байцаагчийн 4 төрлийн актаар 38.0 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, төсвийн орлогод хураан барагдуулахаар шийдвэрлэлээ. Одоогийн байдлаар аймгийн Биеийн тамир спортын газрын 2014-2018 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Орон нутгийн өмчит 41 төсөвт байгууллагад 154.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 1 төсөвт байгууллагад 68 нэрийн 6.9 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

2019 оны 4 дүгээр сарын 17-ны байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19 төсөл арга хэмжээний 22 тэрбум 490 сая төгрөгийн тендерийг зохион байгуулж байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтсээс массын хэмжлээр Төвшрүүлэх, Цэнхэр сумын аж ахуйн тооцоонд ашиглаж байгаа 17 ш жин хэмжүүрт, эзэлхүүний баталгаажуулалтаар Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Хотонт, Хашаат, Өгийнуур, Төвшрүүлэх, Булган сумдын ШТС-ын 56 ш шатахуун түгээгүүрийн шингэн хэмжигчийг баталгаажуулалтанд хамрууллаа.

Аймгийн баталгаажуулалтын зөвлөл 4 удаагийн хурлаар аж ахуйн нэгж , иргэдийн тохирлын гэрчилгээ авахаар ирүүлсэн 94 өргөдөл хүсэлтийг хэлэлцэж 90 хүсэлтэд тохирлын гэрчилгээ шинээр олгох, сунгахаар шийдвэрлэсэн байна. Цэнхэр, Төвшрүүлэх , Өгийнуур сумдын худалдаа үйлчилгээний 17 газар, нийтийн хоолны газар 12, эко гэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 иргэний гэр буудал, жуулчны бааз, амралтын газарт үнэлгээ хийж , стандартын мэдээлэл, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Иргэний бүртгэлийн чиглэлээр

2019 оны 4-р сарын 25-ны байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 1384 бүртгэл хийж гүйцэтгэлээ.

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 160

Гэрлэлтийн бүртгэл - 38

Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 7

Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 6

Эцэг тогтоосны бүртгэл-13

Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 9

Нас баралтын бүртгэл - 59

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 76

Дахин олгосон - 46

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 156

Үндэсний энгийн гадаад паспорт-105

Шилжилт хөдөлгөөн-189

Иргэнд - 487 лавлагаа

Хууль хяналтын байгууллагад - 33 лавлагаа

2019 оны 4-р сарын 25-ны байдлаар иргэн хуулийн этгээдээс 368 мэдүүлгийг хүлээн авч бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 34

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 19

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 0

Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 0

Арилжааны гэрээ – 2

Худалдах худалдан авах гэрээ – 27

Бэлэглэлийн гэрээ – 13

Барьцааны эрхийн бүртгэл –329

Өв залгамжлал – 2
Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 5
Лавлагаа – 5
Бусад эрхийн бүртгэл – 1

Хууль хяналтын байгууллагад 15 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3980613, тэмдэгтийн хураамжид 50721 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 5146600 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн чиглэлээр

Шинэ -12
Өөрчлөлт - 7
Тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон - 18

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Хашаат, Хотонт, Өгийнуур, Булган, Ихтамир, Цэнхэр, Булган, Өлзийт. Батцэнгэл сумдад 18 хяналтын чиглэлээр 106 байгууллага, аж ахуй нэгж, иргэнийг хамруулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, 664 зөрчлийг арилгуулахаар 57 албан шаардлагыг хүргүүлж биелэлтэнд нь хяналт тавьж ажиллаж байна. Мөн дээрх сумдын 45 байгууллага, аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, эрсдэлийг бууруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 205 заалт бүхий 36 зөвлөмжийг хүргүүллээ.

Ой, ан байгалийн ургамал түүж бэлтгэж байгаа байдалд урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд ойн сан бүхий Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Булган, Ихтамир сумдын нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж нийт 9 аж ахуй нэгж, 6 иргэний үйл ажиллагааг хамруулсан.

Шүүхийн шинжилгээний алба криминалистикийн шинжилгээ 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 44, шүүх эмнэлгийн шинжилгээ 52, тусгай шинжилгээ 31-ийг тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 3-р сард нийт 172 гэмт хэрэг гарсны дотор хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 40, хулгайлах гэмт хэрэг 78, үүний дотор малын хулгайн гэмт хэрэг 41 гарсан бөгөөд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь дунджаар 31.1 хувь байна.

Мөн Онцгой байдлын газрын даргын баталсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 20 аж ахуйн нэгж, байгууллагад зохион байгуулан хийж хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчил 102, газар дээр нь арилгуулсан зөрчил 28, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 20-г бичиж хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Аймгийн Онцгой байдлын газарт Галын зөрчлийн дуудлагаар 2 удаа гарч зөрчил гаргасан иргэдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллалаа.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэргүйцэтгэх газарт 1871161.9 төгрөгийн мөнгөн дүн бүхий 423 гүйцэтгэхбаримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 28.8, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 12.4 байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс массын хэмжлээр Төвшрүүлэх сум, Цэнхэр сумын аж ахуйн тооцоонд ашиглаж байгаа 17ш жин хэмжүүр, эзэлхүүний

баталгаажуулалтаар Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Хотонт, Хашаат, Өгийнуур, Төвшрүүлэх, Булган сумдын ШТС-ын 56 ш шатахуун түгээгүүрийн шингэн хэмжигчийг баталгаажуулалтанд хамрууллаа.

Аймгийн баталгаажуулалтын зөвлөлийн 4 удаагийн хурлаар аж ахуйн нэгж, иргэдийн тохирлын гэрчилгээ авахаар ирүүлсэн 94 өргөдөл хүсэлтийг хэлэлцэж 90 хүсэлтэд тохирлын гэрчилгээ шинээр олгох, сунгахаар шийдвэрлэсэн байна. Цэнхэр, Төвшрүүлэх, Өгийнуур сумдын худалдаа үйлчилгээний 17 газар, нийтийн хоолны газар 12, эко гэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 иргэний гэр буудал, жуулчны бааз, амралтын газарт үнэлгээ хийж, стандартын мэдээлэл, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл 2019 оны 2-р сарын 14-ний өдрөөс 4 сарын 15-ны өдрүүдэд улс орон даяар явагдаж дууслаа. Элсэлтийн ерөнхий шалгалтад орохоор Архангай аймгаас нийт 500 сурагч онлайнаар бүртгэлээ хийлгэн баталгаажуулсан байна. Өмнөх онд төгссөн 43 сурагч мөн ЭЕШ өгөхөөр хүсэлтээ гаргасан байна.

Засгийн газрын 2013 оны 37-р тогтоолын дагуу Монгол хэл бичгийн шалгалтыг зохион байгуулан явууллаа. 1-р ээлжийн шалгалтыг 3-р сарын 23-ны өдөр, 2 дахь ээлжийн шалгалтыг 4-р сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Монгол хэл бичгийн 1-р ээлжийн шалгалтад Архангай аймгаас 472 шалгуулагч орж, ирц 94,4 хувьтай байлаа. Эхний ээлжийн шалгалтад босго оноо 400-д хүрээгүй болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шалгалтандаа орж амжаагүй сурагчид 4-р сарын 20-ны өдөр зохион байгуулсан шалгалтад хамрагдсан бөгөөд нийт 81 сурагч хамрагдав.

3-р сарын 26-наас 4-р сарын 10-ны өдрүүдэд улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг 15 хичээлээр 57 ангилалд Архангай аймагт зохион байгууллаа. Олимпиадад Архангай аймгийн ЕБС-ын 278 багш, 622 сурагч оролцов. Багийн дүнгээр Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын Лаборатори 1-р сургууль 17 алт, 12 мөнгө, 6 хүрэл медалиар тэргүүн байр, Эрдэнэбулган сумын 3-р сургууль 7 алт, 7 мөнгө, 4 хүрэл медалиар дэд байр, Өлзийт сумын ЕБС 6 алт, 3 мөнгө, 2 хүрэл медалиар гутгаар байрыг тус тус эзэллээ. 2-ын даваанд аймагтаа тэргүүлсэн багш, сурагчид улсад зохион байгуулагдах 3-ын давааны олимпиадад оролцохоор бэлтгэлээ хангаж байна.

Насан туршийн боловсролын төвөөс гэр бүлийн боловсрол олгох чиглэлийн хүрээнд 7 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 200 гаруй иргэдийн гэр бүлийн боловсролыг дээшлүүллээ.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 51 уншигч шинээр бүртгэж, 1264 ирэгсэдэд 1500 ном, 259 сонин, 23 сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар 15 уншигч шинээр бүртгэж, 800 ирэгсэдэд, 1326 номоор, гэрээр ном олгох

үйлчилгээгээр 142 ирэгсэдэд 209 ном, 130 ширхэг сонин, сэтгүүлээр тус тус үйлчилсэн байна.

4-р сарын 23-ны өдөр "Дэлхийн номын өдөр"-ийг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сангаас жил бүр зохион байгуулдаг "Автобустай уншлага - 2019" арга хэмжээг зохион байгуулж Булган сумын ЕБС-ийн 8, 9-р ангийн 46 сурагч, номын санч, багш нар хамрагдлаа.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын улсын тооллого дуусч тооллогын ажлын явц, үр дүн, тооллогын тайлан, улсын тооллогын музейн дэвтэр, орон нутаг судлах танхимын дэвтэр, музейн үзмэрийн гэрэл зураг DVD 8 ширхэг, сумдын орон нутаг судлах танхимын үзмэрийн гэрэл зураг DVD 2 ширхэгийг тус тус Соёл урлагийн газарт 4-р сарын 11-ний өдөр хүлээлгэн өгсөн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр

Хүний нөөцийн сургаж чадавхижуулах ажлын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилийн төлөвлөгөөний дагуу их эмчийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад 3, дээшлүүлэх сургалтад 1, сувилагч тусгай мэргэжилтний төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 4, дээшлүүлэх сургалтанд мэргэжил дээшлүүлэх сургалтанд 7 хүнийг төсвийн зардлаар суралцуулж байна.

Эрүүл мэндийн салбарын санхүү бүртгэлийн ажилтныг хууль тогтоомж, журам, мэдээ мэдээллээр ханган мэдлэг ур чадварыг сайжруулах үүднээс “Эерэг хандлага-ээлтэй үйлчилгээ” сургалтыг 4-р сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 50 орчим хүнийг хамруулсан.

“Цусны даралт ихсэлт, чихрийн шижингээс урьдчилан сэргийлье” 3 сарын аяны хүрээнд аймгийн төвийн 5 байгууллагын 127 ажилтанд байгууллага дээр нь цусны даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг хийж, бие бялдрын хөгжлийн түвшинг тогтоох сорил авч, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгаа авсан.

“Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг” жишиг үйл ажиллагааны хүрээнд 1-р цэцэрлэгийн эцэг, эхчүүдэд хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд, эрүүл зохистой хооллолт, эрүүл ахуйн зөв дадал хэвшил, хүүхдийн бие бялдрын хөгжил, идэвхтэй хөдөлгөөн гэсэн сэдвүүдээр 8 удаагийн сургалт зохион байгуулж, 185 эцэг, эх хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэв.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

Европын холбооны “Техник мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл-1”-н дэмжлэгтэйгээр Архангай аймагт хийгдэх “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, чанарын судалгаа”-г авахаар аймгийн Засаг даргын 2019 оны 3-р сарын 19-ний өдрийн А/112 дугаар захирамжийн дагуу 3 ажлын хэсэг байгуулагдан 4-р сарын 15- 4-р сарын 23-ны хооронд сумдад ажиллаж ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажиллаж байгаа 18-34 насны залуучууд, малчид, ажилгүй иргэд, ЕБС-ийн 9.12 ангийн сурагчид гэсэн зорилтот бүлгийн нийт 6000 гаруй иргэдийг хамруулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг эхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэлээ хөгжүүлэх бизнес төслийг орон нутгийн хэвлэл

мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй зарлан хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнд 23.000.000 төгрөгний санхүүгийн дэмжлэг олгон байнгын ажлын байраар хангалаа. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 35-с дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний 23 төсөлд 3 жилийн хугацаанд 100 хувь эргүүлэн төлөх нөхцөлтэй 119.000.000 төгрөгний санхүүгийн дэмжлэг олгон байнгын ажлын байраар хангалаа. Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аж ахуй, бичил бизнес эрхлэгч 6 ахмадад эргэн төлөлттэй 15.000.000 төгрөгний санхүүгийн дэмжлэгт хамруулан байнгын ажлын байраар хангалаа.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 4-р сарын 20-ны байдлаар нийт 4915.2 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 156 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 13.91 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 13.08 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1787,3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2019 онд 4462.9 сая төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 237.1 сая төгрөгөөр буурсан.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

Тэтгэврийн даатгалын санд 66,1% буюу 2952,5 сая төгрөг

Тэтгэмжийн даатгалын санд 9,3 % буюу 418,3 сая төгрөг;

ҮОМШӨ-ний даатгалын санд 3,4% буюу 143,3 сая төгрөг;

Ажилгүйдлийн даатгалын санд 1,7% буюу 78,3 сая төгрөг;

Эрүүл мэндийн даатгалын санд 19,5% буюу 870,5 сая төгрөг

2019 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 14,06 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 0,26 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

“Аз жаргалтай гэр бүл” сургалтыг Архангай аймаг дахь Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улаан загалмайн хороо хамтран зохион байгуулж 5 аж ахуй нэгж байгууллагын 290 гаруй алба хаагч хамрагдаж 3 төрлийн 870 гаруй гарын авлага мэдээллийг түгээн өгч, иргэдийн асуултад хариулж санал хүсэлтийг сонслоо.

Оюутан залуусын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэх, цаашлаад оюутан залуусын харилцаа хандлагад нөлөөлж, эерэг өөрчлөлт гаргах зорилготой зохион байгуулж буй “Оюутны оюуны давлагаа-3” уран илтгэлийн тэмцээнийг зохион шалгарсан оюутныг Улаанбаатар хотод 2 дугаар шатанд оролцууллаа.

“Хүүхдийн асуудлаар арга зүйн дэмжлэг үзүүлэх нь” сургалтанд Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн 250 багшийг хамруулж, хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгч багш, ажилтнуудын хүүхдийн эрх, хамгааллын хууль эрх зүй, хүүхдийн хөгжлийн болон сэтгэл зүйн онцлог, хүүхэд хамгаалал, эцэг эхийн зөвлөлтэй ажиллах, үр дүнтэй удирдах талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Аймгийн 19 сумын 101 багийн 3.7 сая га бэлчээрт 14.3 мянган малчин өрхөд 5.5 сая толгой мал хаваржиж байна.

2019 онд аймгийн хэмжээнд 2365.0 мянган толгой эх малын 80 гаруй хувь буюу 1892.0 мянган толгой хээлтэгч хээлтүүлэгт орсон. Өнөөдрийн байдлаар 1079.3 мянган толгой эх мал төллөж 1060.5 мянган толгой төл бойжиж байгаа нь 98.3 хувьтай. Мал төлөлт 45.6 хувьтай байна.

Малын зүй бус хорогдол нийт 15.4 мянган толгой үүнээс адуу 1148 толгой, үхэр 1936 толгой, хонь 6910 толгой, ямаа 5807 толгой мал хорогдсон байна. Үүнээс хээлтүүлэгч – 80 толгой байна.

Аймгийн хэмжээнд 2439 уст цэг байна. Үүнээс 704 гол горхи, 706 булаг шанд, 195 нуур цөөрөм, 22 рашаан, 954 худаг байна.

Инженерийн хийцтэй гүн өрмийн 737 худаг, энгийн уурхайн 211 худаг, 6 усан сан тоологдсоноос 812 худаг буюу нийт худгийн 85.1 хувийг ашиглаж, нийт малчин өрх, мал сүргийн 65 хувь нь усаар хангагдаж, өвөл цас бага орсноос нийт мал сүргийн 35 орчим хувь усан хангамжийн дутагдалтай хаваржиж байна.

Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 75.3 мянган тн өвс, 1057 тн гар тэжээл, 173 тн сүрэл, 1584 тн ногоон тэжээл, 429 тн үйлдвэрийн тэжээл, 5 тн дарш, 1886 тн давс хужир шүү бэлтгэсэн одоогийн байдлаар 90 гаруй хувийг нь ашигласан.

Аймгийн аюулгүй нөөцөд 40 тн хивэг, 2000 ширхэг ашигт долооц байна.

Газар тариалан

2018 онд 9994.3 га талбайд тариалалт хийж 9680 га талбайг уриншилсан бол 2019 онд 14.2 мянган га талбайд тариалалт хийхээр зорилт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 107 аж ахуйн нэгж, 625 иргэн газар тариалангийн үйлдвэрлэлийг дагнан эрхэлж байна.

Үүнээс:	Үр тариа	9680 га
	Тэжээл	2500 га
	Тосны таримал	1500 га
	Төмс	380.5 га
	Хүнсний ногоо	144 га талбайд тус тус тариална.

Уринш 10.8 мянган га талбайд боловсруулалт хийхээр төлөвлөн бэлтгэл ажлаа хангаж байна.

Мөн ХХААХҮЯамнаас зарласан жимс жимсгэнийн суулгацыг зээлээр олгох ажлыг зохион байгуулж, 13 сумын 40 гаруй иргэн, аж ахуйн нэгж 200 чавга, 210 бэсрэг алим, 930 үхрийн нүд, 5300 чацарганын суулгацын захиалгыг хүргүүлсэн. Ирэх сарын 10-ны дотор суулгацыг иргэдэд олгоно.

Хаврын тариалалтанд шаардагдах 1373.5 тн улаанбуудайн үр, 210.6 тн шатахуун, 53.6 тн ургамал хамгаалалын бодис болон 820 тн бордооны захиалгыг аж ахуйн нэгж, иргэдээс авч ХХААХҮЯам болон Тариалан эрхлэлтийг дэмжих санд хүргүүлсэн.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчны чиглэлээр

Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Аялал жуулчлалын дэд хөтөлбөр, “Архангай аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2016-2026” бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдлага болгон төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримталж буй бодлого, төлөвлөлт, хууль эрх зүй, стандарт шаардлагууд болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Архангай аймгийн аялал жуулчлал”-ын уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлэгт аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг эко гэр, гэр буудал, жуулчны баазуудын 150 гаруй төлөөлөл хамрагдлаа.

“Хотоо цэвэрлэе, Хандлагаа өөрчилъе” уриатайгаар бүх нийтийн хог цэвэрлэгээ ажлыг зохион байгуулж 211 аж ахуйн нэгж, байгууллагын 3200 гаруй ажилтан албан хаагчид 219 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэгт төвлөрүүллээ. Мөн байгаль орчны салбарын байгууллагууд 3 га газарт үүссэн хур хог хаягдлыг цэвэрлэж 60 орчим тонн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүллээ.

Барилга, дэд бүтцийн чиглэлээр

4-р сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төвийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын албаны шинжээчидтэй хамтран аймгийн ГХБХБГ-аас тус аймагт үйл ажиллагаа явуулж буй хуванцар хаалга цонхны 4 үйлдвэр, хүрмэн гулдмайн 2 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай танилцан тохирлын гэрчилгээнд хамрагдахад бүрдүүлэх бичиг баримт, үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй танилцан заавар зөвлөмж өгсөн байна.